



Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

СУРГАЛТ-СЕМИНАР,
ТӨРИЙН ОРДОН
2010-Р 11-Р САРЫН 25

Онцлог

- Үндсэн хуулийн дараа орохуйц чухал ач холбогдолтой баримт
- Үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн суурь
- Төрийн нэгдмэл бодлого залгамж чанарыг хангах
- УИХ-ын хурлаар баталсан эрх зүйн баримт
- Үндэсний зөвшилцлийн тулгуур баримт
- Төр, нийгэм, иргэдийн хамтын ажиллагаагаар хангах



ОНЦЛОГ

- Аюулгүй байдлын салбар, эрх зүйн орчны өргөн хүрээтэй шинэтгэлийг эхлүүлсэн.
- Монгол Улсын Ерөнхийлөгч, ҮАБЗ-ийн Тэргүүний санаачлага
- Төр, олон нийтийн байгууллагууд, иргэд, эрдэмтэн, судлаач, УИХ-ын гишүүдийн өргөн оролцоотойгоор боловсрогдсон
- 1994 онд батлагдсан үзэл баримтлал түүхэн нэн чухал үүрэг гүйцэтгэсэн, түүний шинэчлэл, үргэлжлэл



ӨНӨӨГИЙН ШИНЭ НӨХЦӨЛД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БОЛСОН

- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал анх батлагдаж байх үед нийгмийн байдал өөр байсан
- аюулгүй байдлын гадаад, дотоод нөхцөл байдал өөрчлөгдлөө
- глобалчлагдсан ертөнцөд аюулгүй байдалд шинэ, олон төрлийн эрсдэл үүсэн бий болж байна
- хоёр том гүрний дунд оршдог, далайд гарцгүй, зах зээлээс алслагдмал, буурай орон байсан бол өдгөө дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт орших болсон
- геополитикийн ашиг сонирхлын солбицол болсон
- эрдэс, баялаг, эрчим хүчний нөөцийн төлөөх өрсөлдөөн даамжрах болсон



ӨНӨӨГИЙН ШИНЭ НӨХЦӨЛД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БОЛСОН

- дэлхий нийтийг хамарсан хямрал, халдварт өвчин, цаг уурын өөрчлөлт, гамшигт манай улс өртөх магадлал их болсон.
- мэдээлэл, харилцааны технологийн дэвшлээс үүдэн мэдээлийн ертөнцөд томоохон өөрчлөлт гарч, мэдээлэл харилцааны цоо шинэ орчин бий боллоо
- үндэсний эв нэгдэл, ухамсар, хувь хүний оюуны дархлаад нөлөөлөх эрсдлүүд үүсч байна
- мэдээлэл өөрөө үндэсний нөөц баялаг, улс орны хөгжил, дэвшилд нөлөөлөх чухал хүч болсон
- улс төрийн тогтоц, нийгмийн бүтцэд шинэ үзэгдлүүд бий болсон



ШИНЭЛЭГ ХАНДЛАГА: ХҮН ТӨВТӨЙ, ЦОГЦ, ТОДОРХОЙ

- Үндэсний аюулгүй байдал гэдгийг өмнө нь уламжлалт улс төр, цэрэг, дайны заналхийлэлтэй холбон ойлгож, зөвхөн төр, түүний тусгай байгууллагуудын үүрэг хэмээн явцуу үзэж байсныг өөрчилсөн
- Аюулгүй байдлын тухай ойлголт, цар хүрээ, хангах арга замыг өргөтгөж цогц хэлбэрээр хандах,
- Зөвхөн төрийн үүрэг бус нийгэм, хувь хүний хамтын хүчээр хангах зарчим дээр тулгуурлах,
- төр үндсэн үүргээ гүйцэтгэхдээ иргэдийн оролцоог хангах, санал, бодлыг сонсох, үүссэн асуудлыг шийдвэрлэхэд иргэд нь хамтрах, хяналт тавих боломжийг олгох



ШИНЭЛЭГ ХАНДЛАГА: ХҮН ТӨВТӨЙ, ЦОГЦ, ТОДОРХОЙ

- Хувь хүний аюулгүй, амгалан, эрүүл, хангалуун амьдрал нь нийгмийн тогтвортой байдал, хөгжил дэвшлийн сурвалж болох, энэ нь цаашлаад төр, улс, үндэсний аюулгүй байдлыг хангана,
- төр, нийгэм нь аюулгүй байж иргэнийхээ аюулгүй байдлыг хангана гэсэн хүн төвтэй аюулгүй байдлын үзэл
- хүний эрүүл мэнд, хүрээлэх орчин, хүнс нь аюулгүй байх эрх нь баталгаажсан цогц шийдлийг бий болгох арга замуудыг шинээр тусгасан
- 1994 оны Үзэл баримтлал тунхаг шинжтэй байсан бол тодорхой арга замуудыг томъёолсон



- **Үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам**
-
- **3.1. Оршин тогтнохуйн аюулгүй байдал**
- **3.2. Эдийн засгийн аюулгүй байдал**
- **3.3. Дотоод аюулгүй байдал**
- **3.4. Хүний аюулгүй байдал**
- **3.5. Хүрээлэн буй орчны аюулгүй байдал**
- **3.6. Мэдээллийн аюулгүй байдал**

- **Үндэсний аюулгүй байдал** гэж Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг хангах гадаад дотоод, таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ.

- **Үндэсний ашиг сонирхолд** монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй бөгөөд бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, **эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил** багтана

- Төр, нийгэм, иргэдийн аюулгүй байдал **харилцан уялдаатай хангагдсанаар** Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна.

- Үндэсний аюулгүй байдлаа хангаж чадах эсэх нь **төрийн удирдлагын чадавхаас** шууд хамаарна.



- **Үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл:**

Монгол Улсын

тусгаар тогтнол,

бүрэн эрхт байдал

нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь мөн.

- **Үндэсний аюулгүй байдал баталгаажих:**

төр, нийгэм, иргэдийн аюулгүй байдал

харилцан уялдаатай хангагдсанаар.

- **Үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа:**

Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол мөн.



Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим

- - **Эх оронч үндэсний үзлийг дээдлэх**
 - Үндэсний үнэт зүйлээрээ бахархагч, тэдгээрийг хайрлан хамгаалагч, тээн хөгжүүлэгч байх эх оронч үндэсний үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахыг эрмэлзсэн Монгол Улсын **иргэн бүрийн идэвхтэй** үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны эх үндэс болно.
- - **Төр, иргэний хамтын ажиллагаа**
 - Үндэсний аюулгүй байдлыг хангах нь **төрийн анхдагч үүрэг** мөн. Иргэдээ аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэгтэй байх, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, **хамтран ажиллахад** төр онцгой анхаарна.



- **Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим**
- **Аюулгүй байдлын бодлого цогц байх**
- Монгол Улсын “оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал”, “хүний аюулгүй байдал”, “хүрээлэн буй орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал” **харилцан уялдаатай хангагдсанаар** үндэсний аюулгүй байдал баталгаажна.
- **Мэдлэгт суурилах**
- Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь **мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд** суурилна.



Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим

- **Бодитой хандах**
- Болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц боломжийг үр дүнтэй дайчилна.
-
- **Даяаршлын хүчин зүйлийг харгалзах**
- Даяаршил улс үндэстний бусдаас хамаарах эмзэг байдлыг нэмэгдүүлж, нөгөө талаас үндэсний ашиг сонирхлоо гадаад нөөц бололцоог ашиглан хамгаалж бататгах боломж олгож байгааг оновчтой ашиглана.



Үндэсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн шинэтгэл эхэлж байна.

- Үндэсний аюулгүй байдлын тухай
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль
- Гадаад бодлогын үзэл баримтлал
- Цэргийн номнол
- Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын эрх зүйн орчинг шинэчлэх, салбарын 70 гаруй хуульд нэмэлт өөрчлөлт орно.
- Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн чадавхийг сайжруулах
- Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангах
- Төр, нийгэм, иргэдийн хамтын ажиллагааг хангах арга, замуудыг хуульчлах



ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ЗАМ

1. Оршин тогтнохуйн аюулгүй байдал

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн.

- **Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал**

- Хөрш ОХУ, БНХАУ-тай Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, харилцааны түүхэн уламжлал, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг чухалчилсан, тэнцвэртэй найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогыг үргэлжлүүлэн баримталж, өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа хамтын ажиллагаа хөгжүүлнэ.

- **Хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй бүрэн бүтэн байдал**

- **Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал**

- **Соёл иргэншлийн аюулгүй байдал**



ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Эдийн засгийн **бие даасан байдлаа** хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн **тогтвортой хөгжлийн** загварыг буй болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн.
- олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох,
- хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах,
- санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах,
- эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцын асуудлаар оновчтой бодлого баримтална.



Дотоод аюулгүй байдал

- Хүний эрх, эрх чөлөөг хангах,
- Үндсэн хуульт байгууллыг бататгах,
- Хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлэх,
- Төрийн удирдлагыг бэхжүүлэх,
- Улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжих,
- Нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.



- **Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх**
- **Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх**
- **Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх**
- **Нийгмийн тогтвортой байдал**
- **Хүний аюулгүй байдал**
 - ✓ Эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх
 - ✓ Хүнсний аюулгүй байдал
 - ✓ Амьдрах орчин, орон байрны аюулгүй байдал
 - ✓ Иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах



Хүрээлэн буй орчны аюулгүй байдал

- Байгаль орчны тэнцвэрийг хадгалж,
- Усны нөөцийг хамгаалах,
- Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх,
- Биологийн олон янз байдлын хомсдлоос сэргийлэх,
- Орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн.



Мэдээллийн аюулгүй байдал

- Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах,
- Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн **бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй** байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн.
- Үнэт зүйлийг **хэвшүүлэх**, нийгмийн оюун санааг **төлөвшүүлэхэд** мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдал нэн чухал ач холбогдолтой.
- Нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд **хөндлөнгөөс нөлөөлөх** оролдлогыг хязгаарлана.
- Хэвлэл мэдээллийн байгууллага, хэрэгсэл **гадаадын эрхшээлд** орохоос сэргийлж, мэдээллийн бодит, тэнцвэрт байдлыг хангах нөхцөл бүрдүүлнэ.
- Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, **нууц хамгаалалтыг** шинэ түвшинд гаргах
- Нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана.



ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Эдийн засгийн **бие даасан байдлаа** хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн **тогтвортой хөгжлийн** загварыг буй болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн.
- олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох,
- хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах,
- санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах,
- эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцын асуудлаар оновчтой бодлого баримтална.



ЭДИЙН ЗАГИЙН ГОЛ ЭРСДЭЛҮҮД.

- Газрын тос, хүнс, өргөн хэрэглээний барааны импортоос хамааралтай, түүхий эдийн экспорт голлосон,
- байгалийн баялаг, гадаадын хөрөнгө оруулалтад тавих хяналт алдагдсан, үндэсний үйлдвэрлэл, хөдөлмөрийн нөөц доройтсон, үнийн өсөлтөд өртөмтгий, хэт өрөөсгөл бүтэцтэй хэвээр байна.
- Геополитикийн шинэ эрсдэл: дэлхий дахинаа эдийн засгийн өрсөлдөөн сэргэлдөөний хэлбэрт орж Монгол Улс байгалийн баялгийн төлөөх өрсөлдөөний талбар болоод байна.
- Эдийн засгийн бие даасан байдал хангагдаагүй, стратегийн хүнс, бараагаар өөрийгөө хангаж чадахгүй, гадаад зах зээл, ялангуяа хөрш орнуудаас ихээхэн хамааралтай болж байгаа
- Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихдээ төрийн зохицуулалтыг алдагдуулж үйлдвэрлэлийн үндсэн фондыг өмч хувьчлалаар үрэгдүүлэн доройтуулсан.



ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Шалгуур үзүүлэлт	Босго	1999	2005	2007	2008
1	ДНБ-ний өсөлт, %	5	3.2	7.3	10.2	8.9
2	Аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрийн эзлэх жин	70	28.5	18.6	16.01	16.7
3	Аж үйлдвэрийн салбарт машин зохион бүтээх үйлдвэрийн эзлэх жин	20	0	0	0	0
4	ДНБ-д шинжлэх ухаан, судалгааны ажлын зардлын эзлэх жин	2	0.2	0.2	0.3	0.2
5	ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх жин	-5	-10.6	+2.6	+2.8	-5.0
6	Инфляцийн түвшин	20	10	9.5	15.1	22.1
7	ДНБ-д импортын эзлэх жин	30	62.9	51.04	52.4	61.9
8	Нийт экспортод түүхий эдийн эзлэх жин	60	75.6	45.6	68.9	61.9
9	Хүнсний хэрэглээнд импортын эзлэх жин	30	38.7	47.71	43.9	41.1
10	Нефтийн хэрэглээнд импортоор авч буй хувь	35	100	100	100	100
11	Цахилгаан эрчим хүчний хэрэглээнд импортоор авч буй хувь	30	8.6	4.9	5.3	4.9
12	Гурилын хэрэглээнд импортоор авч буй хувь	30	36.2	64.06	61.3	68.2
13	ДНБ-д гадаад өрийн эзлэх жин	30	100.7	70.6	45.8	50
14	Ядуурлын төвшин (амжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой хүн амын эзлэх жин)	10	35.6	32.2	33.3	35.2
15	Хүн амын дундаж наслалт, нас	70	65	64.58	65.85	67.23

Эдийн засгийн олон тулгуурт бүтэц

- **Өөрийгөө тэтгэх чадавхыг** бүрдүүлж, тодорхой салбарт олон улсын тавцанд **өрсөлдөх чадвартай** олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно.
- **Стратегийн** ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг **олон улс, Европын Холбооны стандартад** нийцүүлэн хөгжүүлнэ.
- **Ил тод, хариуцлагатай** уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг бие даасан хөгжлийг хангах, олон тулгуурт бүтцийг бий болгоход чиглүүлнэ.
- 2020 он гэхэд түлш, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.
- Дэд бүтцийн салбарын хөгжлийг **үндэсний аюулгүй байдлын шаардлагад** нийцүүлж, хөрөнгө оруулалтад эдийн засгийн үр ашгийг шалгуур болгоно.



- Төмөр замын сүлжээг байгуулахдаа Монгол Улсын үндэсний **ашиг сонирхол, хоёр хөрштэй тэнцвэртэй** харилцах зарчмыг эрхэмлэнэ.
- Дамжин өнгөрөх тээврээс **хараат байдлыг бууруулсан** үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг түлхүү дэмжиж, хөгжүүлнэ.
- Боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, **хүний хөгжлийг дээшлүүлэхэд** чиглүүлнэ.
- Шинжлэх ухааны шинжилгээ, судалгаа, инновацийг стратегийн ач холбогдолтой салбаруудад **төвлөрүүлж, эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадавхыг** нэмэгдүүлнэ.
- Дотоодын **хөдөлмөрийн зах зээлээ** хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах замаар ядуурлыг арилгах тууштай бодлого хэрэгжүүлнэ.



Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого

- **Үндэсний хөрөнгө оруулагчдыг дэмжих**, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.
- Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын **нийт хөрөнгө оруулалтын 1/3 -ээс** хэтрэхгүй хэмжээнд байлгана.
- Гадаадын **төрийн өмчит** компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлана,
- Стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын **хэмжээг тэнцвэртэй** байлгах бодлого баримтална.




Төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдал

- Эрүүл, тогтвортой, сахилга баттай санхүүгийн салбарыг төлөвшүүлнэ.
- Засгийн газрын зээлийг бодит салбарт чиглүүлж, зохистой төвшинд байлгана.
- Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана.
- Нөөцийн төрөлжилт, удирдлагыг боловсронгуй болгох
- Мөнгөний бодлогын үр дүнг дээшлүүлж, үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах, хөрвөх чадварыг сайжруулж, тогтворжуулна.
- Дотоодын гүйлгээ, төлбөр, тооцоонд зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтийг хэрэглэж, үндэсний мөнгөн тэмдэгтийн дотоодын зах зээлд эзлэх хувь, хэмжээг зохистой хэмжээнд байлгана.
- Банк дундын эрсдэлийн сан байгуулж, санхүүгийн байгууллагын буруугаас үүдсэн аливаа хохирлыг төр хариуцах зарчмаас татгалзана.
- Гадаад, дотоод томоохон төлбөр, тооцоо, зээл, аккредитивийн хөдөлгөөнд хяналт тавих, эдийн засаг, санхүүгийн салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгаж шийдвэрлэх тогтолцоог хөгжүүлнэ



ДЭЛХИЙН ИХЭНХ УЛС ОРНУУД ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭ СУЛРУУЛЖ
ЭКСПОРТОО НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ БАЙГАА ЭНЭ ҮЕД МОНГОЛ ТӨГРӨГИЙН
ХАНШ ЭРЧИМТЭЙ ЧАНГАРЧ БАЙГАА НЬ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН НОЦТОЙ ҮР
ДАГАВАР АВЧРАХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.



ГХО-ЫН ГАЗРЫН МЭДЭЭНЭЭС:

- Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай 5000 гаруй компаниуд
- 1990-2010 онуудад нийт 3.26 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсан
- 53.4 хувь нь БНХАУ-ын хөрөнгө оруулалт, удаах 7.2 хувьтай нь Канад улсын компаниуд байгаа нь нэг улсын давамгайлалтай байдал тогтжээ.
- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 58.4 хувь нь уул уурхайд, 23 хувь нь худалдаа, 3.6 хувь нь банк санхүүгийн салбарт орсон нь хэт өрөөсгөл байгааг харуулж байна
- 2009 оны татвар төлөлтийн байдлаар нь авч үзвэл Монгол Улсын гол ордуудыг ашиглах тусгай зөвшөөрөл авсан гадаадын компаниуд ААНАОТ, НӨАТ, нөөц ашигласны болон бусад татваруудыг дутуу төлж, зарим нь чөлөөлөгдсөн хэвээр байна.



Төв Азийн уран	10	
Шинь Шинь	21000	15000
Тавантолгой	14507284.6	5200000
Гацуурт	39731.3	
Мобиком	24229061.4	10023969.7
Бороогоулд	23423090	
Цайртминерал	4015115.7	
Скайтел	2519282.2	2184404.6
Оюутолгой	218154.5	171761.7
Чинхуа Мак Нарийн Сухайт	1646787.2	
Юнител	3672901.9	951887.2
Гурвансайхан		
Вестрен проспектор монголия		
Айвенхоу Майнз Монголия		
Эрхэсмайнинг		
Гоби Коул энд Энержи	21626.9	
Петро Матад	17925.8	
Саусгоби сэндс	5278886.5	127732.8

- **Эрчим хүч, эрдэс баялгийн салбарын бодлого**
- Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний **аюулгүй байдлын баталгааг хангахыг** чухалчилж,
- түүхий эдийн **хавсарга**, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын **сөргөлдөөний талбар** болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ.
- Газрын тосны бүтээгдэхүүнээр нэг орноос шууд хараат байдлыг багасгаж, улмаар 2020 он гэхэд дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ бүрэн хангана.
- Эрдэс баялгийн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулна.
- Боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарыг хөгжүүлнэ
- Цөмийн эрчим хүчний салбарыг **үндэсний ашиг сонирхол**, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ.
- Цөмийн **циклийг** хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчний үйлдвэрлэлийг бий болгож, бэхжүүлнэ.



- **Гадаад худалдаа, интеграцийн бодлого**
- Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос **хэт хамааралтай** үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.
- **Гадаад худалдааны алдагдлыг багасгаж**, тарифын болон тарифын бус арга хэрэгслээр дотоодын үйлдвэрлэлийг дэмжих
- Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлнэ.
- Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлхаас сэргийлнэ.
- Түүхий эд бэлтгэл, бөөний болон жижиглэн худалдаанд үнийн зохиомол хэлбэлзэл, **монополь, шударга бус өрсөлдөөнийг** хянан зохицуулна. Дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- Бүс нутгийн болон олон улсын **интеграцад нэгдэх**, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ.
-
-



ИМПОРТООС ХАМААРАЛТАЙ ХҮНС

Хүнсний барааны нэр	Оны эхэн дэх үнэ	Оны дунд үе дэх үнэ	Оны эцсийн үнэ	Импортоос хамааралтай эсэх
Орос дээд гурил	715	930	890	хамааралтай
Хятад дээд гурил	600	800	800	хамааралтай
Цагаан будаа	675	1361	1289	хамааралтай
Шар будаа	600	1057	1167	хамааралтай
Элсэн чихэр	725	948	933	хамааралтай
Сүү	900	713	950	хамааралтай
Ургамлын тос	2250	2975	3057	хамааралтай
Байцаа	675	778	763	хамааралтай
Манжин	600	1033	1000	хамааралтай
Төмс	350	606	539	хамааралтай
Лууван	-	817	700	хамааралтай
Сонгино	578	772	687	хамааралтай
Өндөг	180	211	207	хамааралтай



Дотоод аюулгүй байдал

- Хүний эрх, эрх чөлөөг хангаж,
- Үндсэн хуульт байгууллыг бататгаж,
- Хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж,
- Төрийн удирдлагыг бэхжүүлж,
- Улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж,
- Нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.



- **Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлэх**
- **Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх**
- **Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх**
- **Нийгмийн тогтвортой байдал**
- **Хүний аюулгүй байдал**
 - ✓ Эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх
 - ✓ Хүнсний аюулгүй байдал
 - ✓ Амьдрах орчин, орон байрны аюулгүй байдал
 - ✓ Иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах

